



МОНГОЛЫН АВТОТЭЭВЭРЧДИЙН НЭГДСЭН  
ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

᠒᠐18 оны ᠐᠒ сарын ᠒2 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

“Тээвэрчин төгөл” хөтөлбөр батлах тухай

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалт, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын 2 дугаар тэмдэглэл, холбооны дүрмийн 6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбооны Гүйцэтгэх аппаратад бүх талын дэмжлэг үзүүлж, санаачлагатай ажиллахыг Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

3. “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг дэмжиж ногоон байгууламж байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хамтарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт уламжилсугай.

4. Оршин суугаа хот, дүүрэг, сумандаа “Тээвэрчин төгөл”-ийг тухайн орон нутгийн захиргаа, тус холбоотой хамтран бий болгох, эзэмшиж байгаа тээврийн хэрэгслийн тоо /доод тал нь/-гоор жил бүр мод тарьж, байнга арчилж, хамгаалж, ургуулахыг гишүүн байгууллагууд, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.

5. “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг тухайн аймагтаа хэрэгжүүлж ажиллахыг холбооны салбарын захирал нарт даалгасугай.

6. Гүйцэтгэх захиралд даалгах нь:

а/ хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, гишүүн байгууллагууд, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах, хамтран ажиллах;

б/ тухайн бүс нутгийн байгаль орчинд ургах, амьдрах чадвартай мод, бут, сөөг, ургамлыг мэргэжлийн байгууллагын зөвлөгөөний дагуу суулгаж ургуулах зөвлөмжөөр хангах, мод, бут, сөөг, ургамлыг тээвэрчдийн төгөл бий болгох газар дээр нь нийлүүлж борлуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

в/ “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах арга хэмжээ байнга авч байх;

г/ “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг бүх нийтийн үйлс болгох эрх зүйн орчинг бий болгох чиглэлээр арга хэмжээ авч ажиллах.

7. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн эцсээр Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байхыг Дэд ерөнхийлөгч нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Г.БАТХҮҮ



Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны  
Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн 2018 оны  
05... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## “ТЭЭВЭРЧИН ТӨГӨЛ” ХӨТӨЛБӨР

### **Нэг. Хөтөлбөрийн зорилго**

1.1 Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, нийслэл, орон нутаг, хүн ам төвлөрсөн суурин газруудад тээврийн хэрэгслийн нөлөөгөөр үүсч буй агаарын бохирдол, тоосжилт, тоосонцрын хэмжээг бууруулахад тээвэрчдийн оролцоог нэмэгдүүлж “Тээвэрчин төгөл” байгуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### **Хоёр. Хөтөлбөр боловсруулсан үндэслэл, шаардлага**

2.1 “Тээвэрчин төгөл” хөтөлбөр боловсруулах үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж байна.

2.1.1 Агаарын бохирдлын хэмжээ болон Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа;

2.1.2 Агаарын бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд тээвэрчдийн оролцоог нэмэгдүүлэх;

2.1.3 Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах.

### **Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ**

3.1 Хөтөлбөрийг аймаг, нийслэл, хүн ам төвлөрсөн суурин газруудад хэрэгжүүлэх бөгөөд тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулна.

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

4.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2018 оноос эхлэн жил бүр уламжлал болгох зохион байгуулна.

### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим**

5.1 Агаар бохирдуулагч нь төлбөр төлөгч байх.

5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага бүр идэвхтэй оролцогч байх.

### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

6.1.1 Хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж бий болгох газрын асуудлыг нийслэл, аймаг, сум, дүүрэг, хорооны Засаг дарга нартай хамтран шийдвэрлэх;

6.1.2 Тарьц, суулгац бэлдэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллага болон хувь хүмүүстэй хамтран тухайн сонгосон газрын онцлогт тохирсон тарьц суулгацаар хангах ажлыг зохион байгуулах;

6.1.3 Нийслэл болон орон нутагт мод тарих өдрийг зарлан зохион байгуулж, сонгосон талбайд өөрийн болон байгууллагын нэрэмжит төглийг

бий болгоход уриалж, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг өргөнөөр оролцуулах арга хэмжээ авах;

6.1.4 Жолооч бэлтгэдэг автосургууль, курсууд, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран төгсөж байгаа жолооч бүр мод тарих нөхцөлийг бүрдүүлэх;

6.1.5 Тарьц, суулгац бэлддэг мэргэжлийн байгууллага болон хувь хүмүүстэй хамтран хэрхэн мод тарьж ургуулах, түүнийг арчлах талаар мэдлэг, мэдээлэл, зөвлөгөө өгөх;

6.1.6 “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

6.1.7 Мод тарьж ургуулсан тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад эко наалт олгох.

6.2 Бэлтгэсэн тарьц, ургацыг өөрийн зардлаар худалдан авч сонгосон талбайд тарьж ургуулах, арчлах, өөрсдийн нэрэмжит төгөлтэй болох ажлыг тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд гүйцэтгэнэ.

6.3 Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, байгууллага жил бүр тээврийн хэрэгслийн тоогоор, жолооны курс төгсөж байгаа жолооч бүр нэг, мэргэшсэн жолооч бүр 2 модыг өөрсдийн хөрөнгөөр тарьж ургуулах, усалж, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана.

6.4 Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн хүчээр усалж арчлах боломжгүй тохиолдолд арчилгааны зардлыг нэгдсэн санд жил бүр төвлөрүүлэх бөгөөд арчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага болон хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажилгүй хүмүүсээр гүйцэтгүүлж болно.

6.5 Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооноос энэхүү хөтөлбөрийн 6.3, 6.4-д заасан асуудлыг бүх нийтийн үйлс болгох үүднээс холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрх зүйн орчинг бий болгох эсвэл нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаа, санхүүжилт**

7.1 Хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо ханган, хяналт тавьж ажиллах бөгөөд аймаг, орон нутагт зохион байгуулах ажлыг холбооны салбарууд хариуцан гүйцэтгэж, хяналт тавина.

7.2 Хөтөлбөрийг дараах хувь хүн, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нийслэл, аймаг, сум, дүүрэг, хорооны Засаг дарга нар;
- Тарьц, суулгац бэлдэх болон тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд;
- Жолооч бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, жолооны курсууд;
- Тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагууд;
- Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, жолооч.

7.3 Хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх зарим ажил үйлчилгээнүүдийг төрийн холбогдох бусад байгууллагуудтай зөвшилцөж, хамтран хэрэгжүүлнэ.

7.4 Мод тарьж ургуулах, арчлахтай холбоотой зардлыг тухайн тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага хариуцна.

7.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийг тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор тогтмол хяналт тавина.

#### **Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, түүнийг тайлагнах**

8.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна.

8.1.1 Монгол Улсын ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэж, агаарын бохирдол, тоосонцрын хэмжээ багасаж хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт үзүүлнэ;

8.1.2 Хөтөлбөр хэрэгжүүлэх газруудын мод, сөөгийн үр, жимс, жимсгэнэ, мөчир, тарьц, суулгац бэлтгэдэг байгууллагууд, тэдгээрийн ажилчдын орлого нэмэгдэнэ;

8.1.3 Тээвэрчдийн экологийн боловсрол нэмэгдэнэ;

8.1.4 Үе залгамжилсан өөрсдийн нэрэмжит төгөлтэй болно;

8.1.5 Тээвэрчид өөрсдийн хийж бүтээсэн болон ирээдүйдээ бодит хувь нэмэр оруулж байгаагаараа бахархана.

8.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн эцсээр тайлан гаргаж Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байхыг холбооны Дэд ерөнхийлөгч нар хариуцна.

-----oO-----



Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны  
Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн 2018 оны  
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**“ТЭЭВЭРЧИН ТӨГӨЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Арга хэмжээ   | Гүйцэтгэх хугацаа        | Хариуцах байгууллага  |
|---|---|--------------------------|---|
| 1 | 2   | 3                        | 4   |
| 1 | “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, оролцоог нэмэгдүүлэх, бүх нийтийг хамруулах талаар холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлэх, уриалга гаргах | Жил бүр                  | МАТНХ   |
| 2 | “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах  | Байнга                   | МАТНХ<br>Гишүүн байгууллагууд   |
| 3 | “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламж байгуулах газрын асуудлыг шийдвэрлэх  | Жил бүр                  | МАТНХ холбогдох орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран                   |
| 4 | Сонгосон газрын онцлогийг харгалзан тарьж ургуулах мод модлог ургамлын нэр төрлийг сонгох   | Жил бүр                  | МАТНХ<br>Мэргэжлийн байгууллага, иргэд  |
| 5 | Хөтөлбөрт хамрагдах бүс нутагт тохиромжтой хурдан ургах, амьдрах чадвар сайтай мод, модлог ургамлын үр, тарьц, суулгацыг нийлүүлэх ажлыг зохион байгуулах                       | Жил бүрийн II, IV улирал | МАТНХ<br>Мэргэжлийн байгууллага, иргэд  |
| 6 | Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг өргөнөөр хамруулах                                | Жил бүрийн II, IV улирал | МАТНХ   |
| 7 | Хэрхэн мод тарьж ургуулах, арчлах талаар мэдээ, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж ажиллах   | Байнга                   | МАТНХ<br>Мэргэжлийн байгууллага, иргэд  |
| 8 | Мод тарьж ургуулах, байнга арчлах   | Байнга                   | МАТНХ<br>Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага |
| 9 | “Тээвэрчин төгөл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар жил бүрийн төлөвлөгөө, төсөвт тусгаж ажиллах   | Жил бүр                  | МАТНХ<br>Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага |